

БОДЬ МОД

Бодь мод бол Бурхан багшийн гэгээрлийн бэлгэ тэмдэг билээ. Өнөөгийн бидний харж байгаа сэтгэлд хоногшим энэхүү мод бол тус газарт тэмдэглэгдсэн дөрөвдэх мод бололтой. Энэ газар хавьгүй олон мод суулгасан байж таарах боловч эдгээрийн түүхийг хэзээ ч тэмдэглэж байсангүй. Бодь мод нь хэзээ ямагт мөргөлийн чухал орон болж байсан төдийгүй, эртний баримлуудад хүртэл Бурханы дүрийг хийж бүтээж эхлэхээс хавьгүй өмнө түүнийг дүрсэлж байсан байна. Бодь модны тухай дурдсан хамгийн эртний сурвалж бол Калингабодхи Жатака бөгөөд түүнд бодь суудал ба түүний эргэн тойрныг Сиддхартха Гаутамын аугаа их явдлын өмнө ямар байснаар нь тод томруун дүрсэлсэн байдаг.

Тус модны түүхийн нэг хувилбар холбогдох домгуудынхаа хамтаар Ашокавадана-д байдаг. Энэ зохиолд Ашока хаан бурханы шашинд орж бодь модыг шүтэх болсон тухай өгүүлдэг. Түүний хатан Тишья Ракшита, хаан маш их цагаа тус модыг шүтэж дэргэд нь өнгөрүүлэх болсонд хилэгнэж, модыг цавчуулахаар хүн явуулсан байна. Сүйтгэгдсэн модыг хараад Ашока түүний хожуулын дөрвөн талд шороо овоолж, үндсийг нь сүүгээр норгожээ. Тэгэхэд нь мод гайхамшигтайгаар сэргэж, 37 метр шахуу болтлоо ургасан ажээ.

Ямар ч л байсан Сюань Цзан аялалынхаа үед өөр нэг түүх сонссон бөгөөд түүнийгээ бичиж авчээ. Түүний өгүүлснээр модны үндсийг анх цавчин шатааж сүйтгэхийг оролдсон хүн бол чухамхүү Ашока хаан өөрөө байжээ. Гэвч галын дундаас мод харагдахад хаан хийсэн зүйлдээ гэмшиж үндсийг нь сүүгээр норгосон байна. Ордондоо эргэж ирэхгүй удаад байхад нь түүнийг хүлээж ядсан хатан нь модыг дахиж цавчуулахаар хүн явуулсан аж. Тэгэхэд нь Ашока модонд тахилга үйлдээд дахин норгосон бөгөөд ингэхэд тэр хэд хоног ч бололгүй сэргэжээ. Тэрээр модыг тойруулж гурван метрийн өндөр чулуун хана босгосон байна. Мөн түүнчлэн тус тэмдэглэлд Ашока хааны Сангхамитта, Махендра хэмээх хүү, охин хоёр бодь модны суулгацыг Шри Ланка руу авч очсон тухай өгүүлсэн байдаг. Тэр мод Шри Ланкийн Анурадхапурад өнөөг хүртэл байгаа бөгөөд тасралтгүй тэмдэглэж ирсэн түүхтэй ажгуу.

Өөр үед бодь модыг барагцаалбал м.э. нэгдүгээр зууны үед Хануманта хаан, түүнээс хойш дахиад м.э. 600 онд Шива тэнгэрийн улангассан шүтэн бишрэгч Сасанка хаан төр барьж байх үедээ сүйтгэж байжээ. Сюань Цзан аян замын тэмдэглэлдээ дээрх үйл явдлыг тусгасны зэрэгцээ цааш нь тус модны суулгацыг м.э. 620 онд бурханы шашныг шүтэгч Пурнаварма хаан тарьж ургуулсан тухай өгүүлсэн байна.

Мөн түүнчлэн Сюань Цзан Энэтхэгийн бүх нутгаас ирсэн Вайсакха бүр хийгээд мянга мянган хүмүүс сүмийн дэргэд цуглаж, уг модны үндсийг анхилуун үнэртэй ус ба үнэртэн бүхий сүүгээр услаж, бөөн бөөнөөр нь цэцэг тарааж, хөгжим дуугарган мөргөл үйлдсэн тухай тэмдэглэжээ. Дхармасвамины тэмдэглэлд мөн дээрх маягийн сүсэг бишрэлийн илэрхийллийн тухай тусгасан байдаг: "Тус мод нь өмнө, баруун болон хойд талаараа тоосгон ханатай хэрэм маягийн байгууламжин дотор байж байдаг."

Тод ногоон өнгийн шовх үзүүртэй навчтай. Хаалгыг нь онгойлгоход суваг хэлбэрийн том шуудуу харагдана. Шүтэн бишрэгчид модыг аарц, сүү болон зандан мод, камфор г.м. үнэртнээр тахидаг”.

Анхан үедээ бодь мод нь одоогийнхоос бага зэрэг зүүхэн тийш ургаж байсан бөгөөд Их бодийн сүм баригдахад түүнийг шилжүүлэн суулгасан байна. Өнөөгийн бодь модыг болохоор арван есдүгээр зуунд суулгасан бөгөөд тус мод нь жинхэнэ модны үр байж таарна. Каннингем 1892 онд бичсэн номондоо дараах зүйлийг өгүүлжээ: “1862 оны 12 сард харахад тус мод маш их гэмтээд байсан юм. Баруун зүг рүү ургасан нэг том салаа нь гурван мөчрийнхөө хамтаар ногооноороо байсан хэдий ч бусад мөчрийнх нь холтос нь ховхорч хатсан байлаа. Дараачийн удаа би тус модыг 1871 онд, дараа нь 1875 онд харсан юм. Тэгэхэд тэр бүр ч хатаад байсан ба тун удалгүй 1876 онд модноос үлдээд байсан цорын ганц хэсэг шуурганы үеэр нурж баруун ханан дээгүүр унаснаар хуучин үрэлт мод үгүй болсон юм. Гэлээ ч олон үрийг нь цуглуулаад шинэхэн найлзуур нь байраа эзлэхэд бэлэн болоод байсан юм” хэмээн өгүүлжээ. Өнөөгийн мод мөн л хатаж байна. Ийм болоод байгаагийнх нь нэг шалтгаан үндсийг нь дарж, агаар, ус нэвтрэх бололцоо олгохгүй байгаа боржин шал юм. Бодь модны тойронд энх амгалангийн уур амьсгал, оюуны эрч хүч мэдрэгдэж байдаг. Энх амгалангийн энэхүү өгүүлшгүй мэдрэмжийг төрүүлж чадах газар энэ дэлхий дээр цөөхөн байх ажгуу.

Гадаахь очирт суудал

Бодь модон дор гадаахь очирт суудал байх бөгөөд тэр бол Их бодийн сүмийн орчин тойрон дахь өнөө хэр үзэж болох объект юм. Энэхүү тэгш өнцөгт чулуун хавтанг анхны сүмд хамгийн хуучин очирт суудлын дээр байрлуулж, хожмоо бодь модны байрлалыг өөрчлөхөд гадагш нь гаргаж энд байрлуулсан, эсвэл түүнийг модны дэргэд болсон үйл явдлын таних тэмдэг болгож зориуд хийсэн байж болох юм. Гадаахь очирт суудал нь 143 X 238 X 13,5 см хэмжээтэй бөгөөд өнгөлсөн чунар хэмээх элсэн чулуугаар хийгджээ. Дээд тал нь ховор тохиолдох геометрийн дүрсээр чимэглэгдсэн байх ба захаар нь одой далдуу мод болон галуун хээтэй хөвөө байдаг юм. Нүүдэллэж амьдардаг зэрлэг галууг /hansa/ эртний бурханы шашинд хүлээснээс алдарсны бэлгэ тэмдэг болгодог байжээ. Тус очирт суудлыг эсвэл Ашока хаан өргөсөн, эсвэл шүтэн бишрэгч хэн нэг нь захиалж Санчигаас олдсон Ашока хааны баганы орой дээрхтэй адил одой далдуу мод болон галуун хээ хийлгэсэн бололтой. Очирт суудлын дээд талд чамин хийцтэй алтадсан шүхэр байдаг. Тэр бол Шри Ланкийн ерөнхийлөгч асан Лате Ранасингх Премадашагийн гэргийнхээ хамт 1991 онд өргөн барьсан бэлэг юм. Үүнээс гадна тэр хоёр хашлагыг хүрээлэх хоёр хаалга бүхий алтадсан хайс хандивласан байна. Гадна талаар нь хорь гаруй жилийн өмнө сүмийн удирдах хорооноос босгосон чулуун хашлага бий. Харамсалтай нь тус очирт суудал хэдэн жилийн өмнөх шиг мөргөлчдөд нээлттэй байхаа больсон юм.

Орчуулагчийн тайлбар: Дээрхи орчуулга бол Суреш Бхатиягийн "Их бодийн сүм" буюу "Mahabodhi temple" /англиар/ хэмээх Энэтхэгийн Бодгая дахь Бурхан багшийн бодь модны дор гэгээрсэн газар байгуулагдсан алдарт сүмийн цогцолборын тухай бүтээлийн хэсэг юм. Энэ номыг нь зохиогчийнх нь хүсэлтээр би Монгол хэлэнд 2005 онд орчуулсан бөгөөд хэвлүүлээгүй байгаа.

Англи хэлнээс орчуулсан доктор О.Чимэг